

1 Ахлагчаас сонгогдсон эзэгтэй болоод түүний хүүхдүүдэд: Миний, зөвхөн миний биш, бас үнэнийг мэддэг бүгдийн та нарыг үнэн дотор хайрладаг нь **2** бидний дотор байгаа бөгөөд бидэнтэй үүрд хамт байх үнэний төлөө юм. **3** Эцэг Бурхан ба Эцэгийн Хүү Есүс Христээс ирсэн нигүүлсэл, өршөөл, амар тайван нь үнэн хийгээд хайрын дотор бидэнтэй хамт байх болно.

4 Эцэгээс бид тушаал хүлээн авсан шиг таны хүүхдүүдийн зарим нь үнэний дотор явж буйг мэдсэндээ би их баярласан. **5** Эзэгтэй, бие биеэ хайрлахыг эдүгээ би танаас гуйж байна. Үүнийг шинэ тушаал болгон танд бичиж байгаа бус, харин эхнээсээ энэ нь бидэнд байсан билээ. **6** Бид Түүний тушаалуудын дагуу явцгаая. Энэ бол хайр билээ. Та нар эхнээсээ сонссончлон түүний дотор явах нь тушаал юм. **7** Олон мэхлэгчид ертөнцөд орж ирсэн. Тэд ЕсүсХристийг махан биеэр ирснийг хүлээн зөвшөөрдөггүй ажээ. Энэ бол мэхлэгч бөгөөд Христийг эсэргүүцэгч мөн. **8** Та нар бидний гүйцэлдүүлснийг алдалгүй, харин дүүрэн шагналыг хүлээн авахын тулд өөрсдийгөө хяна. **9** Хэтэрч, Христийн сургаал дотор байдаггүй хэнд ч Бурхан байхгүй. Сургаал дотор байгч нэгэнд Эцэг ч, Хүүч байна. **10** Хэрэв хэн нэгэн нь та нар уруу ирэхдээ энэ сургаалыг авчрахгүй бол, түүнийг гэртээ бүү оруул. Түүнтэй мэндэлж болохгүй. **11** Түүнтэй мэндэлж буй хүн нь түүний бузар үйлсэд оролцож байгаа хэрэг юм.

12 Та нарт бичмээр зүйл надад олон байгаа ч би цаас янтай нийлүүлэхийг хүсэлгүй, харин та нар уруу очиж, нүүр нүүрээрээ ярилцана гэдэгт найдаж байна. Ингэснээр бидний баяр хөөр дүүрэн болно. **13** Таны сонгогдсон эгч дүүгийн чинь хүүхдүүд, танд мэнд хүргэж байна.